БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/32/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг:erbolu@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан. ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ **Error! Bookmark not defined.**
4.1 Залруулсан алдаа ........ 15
4.2 Төлбөрийн акт ........ 15
4.3 Албан шаардлага ........ 15
4.4 Зөвлөмж ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.25 № 200

танай ______ -ны № ______ -т

БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.ЕСЕН ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **142,529,964.20** | **127,021,104.11** |
| **33** | **АВЛАГА** | 17,514,100.00 | 880,969.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,550,423.00 | 880,969.00 |
| **335** | **Бусад авлага** | 15,963,677.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 15,082,708.00 | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 880,969.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 125,015,864.20 | 126,140,135.11 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,305,335.00 | 2,305,335.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,305,335.00 | 2,305,335.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 80,000.00 | |
| **354** | **Хангамжийн материал** | 122,630,529.20 | 123,834,800.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,297,880.00 | 1,377,880.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 106,398,440.20 | 112,377,210.11 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,871,691.00 | 1,871,691.00 |
| 35460 | Хүнсний материал | 13,062,518.00 | 8,208,019.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,227,323,363.03** | **2,396,218,099.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,227,323,363.03 | 2,396,218,099.31 |
| 391 | Газар | 50,171,600.00 | 51,696,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,177,151,763.03 | 2,344,522,099.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,107,730,581.00 | 2,327,809,361.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (85,879,307.43) | (151,208,554.96) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 7,729,560.00 | 7,729,560.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (7,729,560.00) | (7,729,560.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 280,038,343.78 | 284,345,143.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (244,781,100.15) | (250,646,876.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 121,933,452.80 | 121,933,452.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (73,241,323.09) | (80,840,748.69) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 15,000,000.00 |
| 39217 | Ном | 71,351,116.12 | 78,130,321.44 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | - | - |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,369,853,327.23** | **2,523,239,203.42** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,936,595.00** | **23,314.00** |
| **413** | **Өглөг** | 2,936,595.00 | 23,314.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,936,595.00 | 23,314.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,366,916,732.23** | **2,523,215,889.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,366,916,732.23 | 2,523,215,889.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 462,853,876.30 | 462,853,876.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 778,594,597.59 | 934,893,754.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 778,594,597.59 | 778,594,597.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 156,299,157.19 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,125,468,258.34 | 1,125,468,258.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,369,853,327.23** | **2,523,239,203.42** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,832,998,437.20** | **2,099,681,190.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,213,537.20** | **5,185,504.91** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,213,537.20 | 5,185,504.91 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,213,537.20 | 5,185,504.91 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,213,537.20 | 5,185,504.91 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,805,784,900.00** | **2,094,495,685.32** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,660,393,600.00 | 1,917,585,585.32 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | 224,162,385.32 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,660,393,600.00 | 1,693,423,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 9,064,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 9,064,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 145,391,300.00 | 167,846,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 145,391,300.00 | 152,846,000.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | | 15,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,850,555,458.47** | **1,945,542,033.04** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,850,555,458.47** | **1,945,542,033.04** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,791,015,634.47 | 1,890,440,403.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,385,532,095.00 | 1,409,255,471.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,236,587,095.00 | 1,318,424,371.00 |
| 210104 | Урамшуулал | 135,331,600.00 | 77,217,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,613,400.00 | 13,613,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 174,543,331.00 | 183,613,468.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 174,543,331.00 | 127,885,068.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 13,932,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 11,145,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,786,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 27,864,200.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,437,236.00 | 149,230,820.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,617,536.00 | 4,956,820.00 |
| 210302 | Түлш, халаалт | 136,819,700.00 | 144,274,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,344,880.00 | 8,348,235.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,987,730.00 | 1,043,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,707,600.00 | 1,890,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 669,000.00 | 756,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 525,100.00 | 179,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 947,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,508,450.00 | 4,479,735.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,627,061.00 | 50,937,629.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 409,700.00 | 479,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,355,961.00 | 49,082,229.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,861,400.00 | 1,376,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 507,780.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 507,780.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,354,000.00 | 544,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,354,000.00 | 544,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,736,600.00 | 2,085,551.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,086,600.00 | 1,485,551.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 650,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,440,431.47 | 85,917,449.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,134,050.00 | 3,990,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,914,400.00 | 3,133,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,391,981.47 | 78,794,449.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 59,539,824.00 | 55,101,630.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,670,500.00 | 47,287,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,670,500.00 | 47,287,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 35,915,260.00 | 4,608,630.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,915,260.00 | 4,608,630.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,** | 4,954,064.00 | 3,205,100.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,954,064.00 | 3,205,100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(17,557,021.27)** | **154,139,157.19** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 3,134,050.00 | 2,160,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 3,134,050.00 | 2,160,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 3,134,050.00 | **2,160,000.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(14,422,971.27)** | **156,299,157.19** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,853,876.30** | **1,125,468,258.34** | **778,594,597.59** | **0.00** | 2,366,916,732.23 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,853,876.30** | **1,125,468,258.34** | **778,594,597.59** | **0.00** | 2,366,916,732.23 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,853,876.30** | **1,125,468,258.34** | **778,594,597.59** | **0.00** | 2,366,916,732.23 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | | 156,299,157.19 | | 156,299,157.19 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,853,876.30** | **1,125,468,258.34** | **934,893,754.78** | **0.00** | **2,523,215,889.42** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,805,784,900.00** | **1,855,333,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,805,784,900.00** | **1,855,333,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,660,393,600.00 | 1,693,423,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,660,393,600.00 | 1,693,423,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 9,064,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | - | 9,064,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 145,391,300.00 | 152,846,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн | 145,391,300.00 | 152,846,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,803,176,900.00** | **1,846,806,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,803,176,900.00** | **1,846,806,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,743,637,076.00** | **1,791,824,670.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,367,386,600.00 | 1,390,255,689.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,218,441,600.00 | 1,299,424,589.00 |
| 210104 | Урамшуулал | 135,331,600.00 | 77,217,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,613,400.00 | 13,613,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 186,996,500.00 | 188,083,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,553,200.00 | 132,355,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,110,700.00 | 13,932,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,488,700.00 | 11,145,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,622,100.00 | 2,786,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,221,800.00 | 27,864,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,437,236.00 | 149,230,820.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,617,536.00 | 4,956,820.00 |
| 210302 | Түлш, халаалт | 136,819,700.00 | 144,274,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,196,300.00 | 5,876,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,080,500.00 | 470,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,701,000.00 | 1,890,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 669,000.00 | 756,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 484,300.00 | 179,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | 947,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,314,500.00 | 2,580,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,559,840.00 | 49,723,530.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 409,700.00 | 479,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,582,245.00 | 46,157,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,567,895.00 | 3,086,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 410,080.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 410,080.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,354,000.00 | 544,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,354,000.00 | 544,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 1,736,600.00 | 2,085,551.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,086,600.00 | 1,485,551.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 650,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,970,000.00 | 5,615,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,830,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,970,000.00 | 3,785,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,539,824.00** | **54,981,830.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,670,500.00 | 47,168,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,670,500.00 | 47,168,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 35,915,260.00 | 4,608,630.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,915,260.00 | 4,608,630.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад** | 4,954,064.00 | 3,205,100.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,954,064.00 | 3,205,100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨНГ ҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,608,000.00** | **8,526,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН** | **2,608,000.00** | **8,526,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,608,000.00** | **8,526,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,608,000.00 | 8,526,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,608,000.00 | 8,526,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,608,000.00)** | **(8,526,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,846,269,200.00 | 1,838,455,470.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,846,269,200.00 | 1,838,455,470.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,799,101,100.00 | 1,791,287,370.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,393,210,000.00 | 1,390,255,689.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,302,378,900.00 | 1,299,424,589.00 |
| 210104 | Урамшуулал | 77,217,700.00 | 77,217,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,613,400.00 | 13,613,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 188,083,400.00 | 188,083,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,355,000.00 | 132,355,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,932,100.00 | 13,932,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,145,700.00 | 11,145,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,786,400.00 | 2,786,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,864,200.00 | 27,864,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 151,846,000.00 | 149,230,820.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,572,000.00 | 4,956,820.00 |
| 210302 | Түлш, халаалт | 144,274,000.00 | 144,274,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,941,700.00 | 5,796,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 480,500.00 | 470,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,890,000.00 | 1,890,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,634,600.00 | 756,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 686,500.00 | 429,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,250,100.00 | 2,250,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,225,200.00 | 49,723,530.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 479,400.00 | 479,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,659,200.00 | 46,157,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,086,600.00 | 3,086,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 410,080.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 410,080.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 549,200.00 | 544,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 549,200.00 | 544,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам** | 1,286,500.00 | 1,285,551.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээн | 686,500.00 | 685,551.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,959,100.00 | 5,958,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,959,100.00 | 5,958,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,168,100.00 | 47,168,100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,168,100.00 | 47,168,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 47,168,100.00 | 47,168,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,846,269,200.00 | 1,838,455,470.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,693,423,200.00 | 1,688,814,570.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,693,423,200.00 | 1,688,814,570.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 152846000.00 | 149640900.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 152,846,000.00 | 149,640,900.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 123.00 | 125.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 76.00 | 82.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 43.00 | 42.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 895.00 | 904.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ** | 895.00 | 904.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 895.00 | 904.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **123.0** | **125.0** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 82.00 | 83.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮС | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 39.00 | 40.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **9,064,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **5,094,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 5,094,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 330,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 330,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 800,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 3,964,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,830,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,134,100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **3,970,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 3,970,000.00 |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 3,970,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 9,064,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 9,064,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 9,064,100.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Сургалтын таатай орчин бүрдүүлж суурь болон бүрэн дунд боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1850.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 18.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 153.4 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 17514.1 | 880.9 | -16633.2 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.0 |
| Бараа материал | 125015.8 | 126140.1 | 1124.3 |
| Үндсэн хөрөнгө | 2227323.4 | 2396218.1 | 168894.6 |
| **Нийт хөрөнгө** | **2369853.3** | **2523239.2** | **153385.9** |
| Өр төлбөр | 2936.6 | 23.3 | -2913.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2366916.7 | 2523215.9 | 156299.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2369853.3** | **2523239.2** | **153385.9** |

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг болж 16.6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 126.1 сая төгрөг болж 1.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 62.6 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр 5.2 сая төгрөгийн бараа материалыг хандиваар авч, үйл ажиллагаандаа 64.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2396.2 сая төгрөг болж 168.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдсэн 220.0 сая

төгрөгийн барилгын их засвар , сумын ОНХС-аас хийлгэсэн 15.0 сая төгрөгийн гүний худаг, Боловсролын газраас олгосон 2.5 сая төгрөгийн ном, сумын ЗДТГ-аас олгосон газар эзэмшүүлэх гэрчилгээний үнэ 1.5 сая, төсвийн хөрөнгөөр худалдаг авсан 8.5 сая, нийт 247.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

Урьд оны өр төлбөрийг барагдуулан ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2523.2 сая төгрөг болж 156.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2099.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 266.7 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилт, хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 94.8 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдэж, албан томилолтын зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 1769.7 сая төгрөг, тодотгосон төсөв 1846.3 сая төгрөг байна. Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 76.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалингийн зардал 100.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.5 сая, үдийн хоолны зардал 10.5 сая төгрөгөөр нэмэгдэж, хоолны зардлыг 47.6 сая төгрөгөөр хасагдсан байна. Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг дутуу суулгасантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1846.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1838.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 7.8 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь цалингийн зардал, байр ашиглалтын зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Боловсролын газраас “Тоглоё, тооцоолъё” төслөөр 8.0 сая, хоцрогдол арилгах шалгалтад зориулж 1.0 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Нийт санхүүжилт 1846.3 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 1768.8 сая төгрөгийн зардлыг хасахад 77.5 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 7.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Тус сургууль нь оны эцэст 7.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж төсвийг хэмнэж Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд нийт 2099.6 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1823.7 сая төгрөгийн 147 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн жилийн эцэст НДШ-д 12.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн, хувь хүмүүсээс авах авлага 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн зөрчилд албан шаардлага, Шилэн дансны 5 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардлыг дэлгэрэнгүй шалгаж амжаагүй тул, гүйцэтгэлийн аудитаар шалгах шаардлагатай

Аудитаар зөрчил илрээгүй

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй.

### 4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баяннуур сумын ЕБ-ын 1-р сургууль | | | | | | | | | | |